




МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР  
НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧИД  
2019 ОНЫ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот  
2020 он

## АГУУЛГА


- I. Улсын хилээр нэвтэрсэн зорчигч
  - II. Улсын хилээр орсон гадаадын зорчигч, жуулчид
  - III. Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл
  - IV. Улсын хилээр гарсан дотоодын зорчигч
- Дүгнэлт

## I. УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧ

Монгол улсын хилийн 24 боомтоор 2019 онд 6.1 (давхардсан тоогоор) сая зорчигч нэвтэрсэн байна. Улсын хилээр 2019 онд нэвтэрсэн зорчигчдын тоо 2009 оноос 2.1 дахин, 2014 оноос 40.3 хувиар, өмнөх оноос 2.5 хувиар тус тус өсжээ. Нийт зорчигчдын 5.3 хувь нь хүүхэд байна.

Улсын хилээр нэвтэрсэн нийт зорчигчдын 79.1 хувь нь Монгол улсын иргэд, 20.9 хувь нь гадаадын зорчигчид байна. Нийт зорчигчдын 62.1 хувь нь эрэгтэй, 37.9 хувь нь эмэгтэйчүүд байна.


Зураг 1. Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид, мянган хүн, 2009-2019 он



Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын 75.4 хувь нь авто замын боомт, 3.6 хувь нь төмөр замын боомт, 21.0 хувь агаарын замын боомтоор тус тус нэвтэрчээ.


Хилээр нэвтэрсэн зорчигчдыг боомтуудаар нь ангилан харвал, 37.5 хувь нь Замын-Үүд боомтоор, 21.0 хувь нь Буянт-Ухаа, 11.7 хувь нь Гашуун сүхайт, 10.7 хувь нь Алтанбулаг, 5.7 хувь нь Шивээ хүрэн, 13.4 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

Зураг 2. Монгол Улсын хилээр орсон зорчигчдын тоо, 2019 он



Нийт зорчигчдын 81 хувь нь Замын-Үүд, Буянт-Ухаа, Гашуун-Сүхайт ба Алтанбулаг гэсэн 4 том боомтоор нэвтэрчээ.

Зураг 3. Монгол Улсын хилээр гарсан зорчигчдын тоо, 2019 он



Хүснэгт 1. Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид, боомтоор, 2019 он


	Гарсан	Орсон	АЯЛЫН ЗОРИЛГО			
			Албан ажлаар	Хувийн журмаар	Байнга оршин суух	Бусад
<b>Бүгд</b>	<b>3 052 940</b>	<b>3 043 503</b>	<b>52 680</b>	<b>207 850</b>	<b>2 418 308</b>	<b>364 665</b>
Алтанбулаг	320 193	330 868	4 691	27 511	275 534	23 132
Арц суурь	7 457	7 826	11	2 761	5 023	31
Байтаг	20	17	-	-	17	-
Баянхошуу	31 853	31 495	121	1 718	20 408	9 248
Бичигт	49 637	49 722	294	657	39 329	9 442
Боршоо	53 321	52 958	36	45 351	6 901	670
Булган	35 194	35 213	21	425	33 685	1 082
Бургастай	13 708	13 720	31	13 307	291	91
Буянт-Ухаа	645 446	632 930	33 218	54 240	335 826	209 646
Гашуунсүхайт	356 473	356 805	88	5 644	345 392	5 681
Даян	115	116	-	4	112	-
Замын-Үүд	1 138 716	1 141 119	9 621	26 715	1 039 416	65 367
Сүмбэр	1 428	1 550	16	137	1 078	319
Сүхбаатар	45 878	35 185	3 457	787	11 817	19 124
Тэс	757	872	-	355	512	5
Ульхан	2 170	2 230	108	280	1 536	306
Хавирга	62 933	63 182	160	1 168	59 324	2 530
Ханги	28 785	29 169	5	883	28 200	81
Ханх	23 421	23 539	9	591	10 817	12 122
Ховд	13	14	6	-	1	7
Цагааннуур	55 124	54 802	70	22 344	29 010	3 378
Чойбалсан	24	25	25	-	-	-
Шивээхүрэн	173 264	173 091	52	1 872	168 813	2 354
Эрэнцав	7 010	7 055	640	1 100	5 266	49

## II. УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААДЫН ЗОРЧИГЧ, ЖУУЛЧИД

Монгол Улсын хилээр 2019 онд 3.0 сая зорчигч орсны 637.0 мянга нь гадаадын зорчигчид байна. Энэ нь өмнөх оноос 6.4 хувиар буюу 38.6 мянгаар өсжээ. Тэдний 89.4 хувь нь 30 хүртэл хоног, 8.6 хувь нь 90, түүнээс дээш хоног, 2.0 хувь нь 30-аас 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн байна.

Гадаадын зорчигчдын 61.2 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас, 32.6 хувь нь Европоос, 4.3 хувь нь Америк тивээс, 1.9 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.


Зураг 4. Монгол Улсын хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчид, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2015-2019



Хилээр орсон гадаадын зорчигчдын 32.7 хувийг БНХАУ-ын иргэд, 23.0 хувийг ОХУ-ын иргэд, 16.2 хувийг БНСУ-ын иргэд, 4.0 хувийг Япон улсын иргэд, 3.1 хувийг АНУ-ын иргэд, 2.6 хувийг Казахстан улсын иргэд, 18.4 хувийг бусад улсын иргэд эзэлж байна.

Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдыг аяллын зорилгоор ангилан харвал, 90.6 хувь буюу 577.3 мянга нь аялал жуулчлалын зорилгоор, үлдсэн 9.4 хувь буюу 59.7 мянга нь ажиллах, суралцах, байнга оршин суух гэсэн урт хугацааны зорилгоор иржээ.


Зураг 5. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигч, жуулчин, сүүлийн 10 жилийн байдлаар, мян.хүн



Сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл, Монгол улсад 2009 онд 411.7 мянган жуулчин ирсэн бол 2013-2015 онуудад тогтмол буурч, 2015 онд хамгийн бага 386.2 мянган жуулчин иржээ. Жуулчны тоо 2016 оноос аажмаар өсөж эхэлсэн байна. Жуулчдын тоо 2019 онд 577.3 мянга болсон нь өмнөх онуудтай харьцуулахад өсжээ.


Монгол Улсад ирсэн нийт жуулчдын 69.7 хувь нь II, III дугаар улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд иржээ. Өвлийн улиралд ирэх жуулчдын тоо бага байгаа нь манай орны цаг уурын байдал хатуу ширүүн болон өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй зэргээс шалтгаалсан байх магадлалтай.

Зураг 6. Жуулчдын тоо, улирлаар, сүүлийн 5 жилийн байдлаар, мянган хүн.



Монгол Улсад ирсэн жуулчдын 29.2 хувь нь БНХАУ-аас, 24.6 хувь нь ОХУ-аас, 17.5 хувь нь БНСУ-аас, 4.2 хувь нь Япон улсаас, 3.3 хувь нь АНУ-аас, 2.8 хувь нь Казахстан улсаас, 2.1 хувь нь Герман улсаас, 1.8 хувь нь Франц улсаас ирсэн, үлдсэн 14.5 хувь нь бусад улс орноос ирсэн байна.

Зураг 7. Жуулчдын тоо, улсаар, 2018, 2019 он



Монгол Улсад ирсэн жуулчдын тоог өмнөх онтой харьцуулахад ОХУ, БНСУ, Япон, ХБНГУ-аас ирсэн жуулчдын дүнд эзлэх хувь 0.1-1.6 пунктээр нэмэгдсэн байна. БНХАУ, АНУ, Казакстан, бусад улсаас ирсэн жуулчдын дүнд эзлэх хувь 0.1-1.8 пунктээр буурсан байна. Франц улсын хувьд өмнөх онтой ижил тооны жуулчид ирсэн үзүүлэлттэй байна. Харин 2018 онтой харьцуулахад БНСУ-аас 20.3 хувь, Япон улсаас 16.3 хувь, ХБНГУ-аас 14.7 хувь, ОХУ-аас 9.9 хувь, Франц улсаас 8.2 хувь, АНУ-аас 5.6 хувь, БНХАУ-аас 2.6 хувь, Казакстан улсаас 0.7 хувь, Бусад улсаар 8.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Улсын хилээр орсон гадаад зорчигчид, бүс нутаг, улсаар

	2016	2017	2018	2019
<b>Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг</b>	<b>303 255</b>	<b>345 648</b>	<b>372 876</b>	<b>389 581</b>
БНХАУ	185 824	201 912	216 379	208 449
БНСУ	59 514	76 637	86 013	103 379
Япон	20 568	23 093	21 621	25 163
<b>Европ</b>	<b>138 216</b>	<b>164 403</b>	<b>189 161</b>	<b>207 851</b>
ОХУ	87 655	110 353	133 402	146 783
ХБНГУ	9 879	10 777	11 015	12 654
Франц	9 137	10 154	9 909	10 716
<b>Америк</b>	<b>21 945</b>	<b>24 096</b>	<b>25 767</b>	<b>27 174</b>
АНУ	16 758	17 663	18 866	19 948
Канад	3 564	4 204	4 481	4 501
Бразил	489	745	792	900
<b>Өмнөд Ази</b>	<b>2 876</b>	<b>3 127</b>	<b>3 909</b>	<b>4 381</b>
БНЭУ	1 844	2 082	2 572	2 793
Балба	241	230	349	416
Пакистан	174	255	304	337
<b>Ойрх Дорнод</b>	<b>3 830</b>	<b>3 977</b>	<b>4 806</b>	<b>5 453</b>
Түрк	2 295	2 262	2 779	1 999
Израил	892	911	945	1 158
Катар	186	228	422	866
<b>Африк</b>	<b>1 105</b>	<b>1 416</b>	<b>1 848</b>	<b>2 480</b>
Өмнөд Африк	521	928	1 218	1 764
Египет	95	54	55	72
Этиоп	53	50	67	58
<b>Нийт</b>	<b>471 227</b>	<b>542 667</b>	<b>598 367</b>	<b>636 920</b>


Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 605.9 (95.1%) мянга нь насанд хүрсэн хүн, 408.3 (64.1%) мянга нь эрэгтэйчүүд, 228.5 (35.9%) мянга нь эмэгтэйчүүд, 31.0 (4.9%) мянга нь хүүхэд байна.

Улсын хилээр 2019 онд орсон гадаадын зорчигчдын 61.2 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас, 32.6 хувь нь Европоос, 4.3 хувь нь Америк тивээс, 1.9 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 32.7 хувийг БНХАУ-ын иргэд, 23.0 хувийг ОХУ-ын иргэд, 16.2 хувийг БНСУ-ын иргэд, 4.0 хувийг Япон Улсын иргэд, 3.1 хувийг АНУ-ын иргэд, 2.6 хувийг Казахстан Улсын иргэд, 18.4 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Монгол Улсад урт хугацааны зорилгоор буюу ажиллах, суралцах, байнга оршин суухаар ирсэн 59.7 мянган гадаадын зорчигчдын 67.3 хувь нь БНХАУ-аас, 8.1 хувь нь ОХУ-аас, 5.7 хувь нь Австрали улсаас, 3.5 хувь нь БНСУ-аас, 1.9 хувь нь АНУ-аас, үлдсэн 13.5 хувь нь бусад улс орноос ирсэн иргэд эзэлж байна. 2019 онд ОХУ, Австрали, БНСУ, АНУ, бусад улсаас ажиллах, суралцах, байнга оршин суух зорилгоор ирсэн гадаадын зорчигчдын дүнд эзлэх хувь өмнөх оноос 0.4-3.8 пунктээр өссөн байна. Харин БНХАУ улсаас урт хугацааны зорилгоор ирсэн гадаадын зорчигчдын дүнд эзлэх хувь өмнөх оноос 8.6 пунктээр буурчээ.


Зураг 8. Ажиллах, суралцах, байнга оршин суух зорилгоор ирсэн гадаадын зорчигч, улсаар, 2018, 2019 он



### III. УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Улсын хилээр 2019 онд 2.7 (давхардсан тоогоор) сая тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 17.7 (0.7%) мянгаар бүүрчээ. Тэдгээрийн 39.5 хувийг ачааны машин, 27.8 хувийг суудлын машин, 30.2 хувийг ачааны вагон, 2.5 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Зураг 9. Монгол Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, 2019 он



Нийт тээврийн хэрэгслийн 44.0 хувь нь Замын-Үүд, 19.2 хувь нь Гашуун сухайт, 10.0 хувь нь Шивээ хүрэн, 8.1 хувь нь Сүхбаатар, 7.3 хувь нь Алтанбулаг, 11.4 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна.




#### IV. УЛСЫН ХИЛЭЭР ГАРСАН ДОТООДЫН ЗОРЧИГЧ

Монгол улсын 2.4 (давхардсан тоогоор) сая иргэд 2019 онд гадаадад зорчсон байна. Энэ нь өмнөх оноос 1.9 хувиар буурчээ.

Гадаадад зорчсон Монгол иргэдийн 61.5 хувь нь эрэгтэй, 38.5 хувь нь эмэгтэй, 5.5 хувь нь хүүхэд байна. Тэдний 97.1 хувь нь 30 хүртэл хоногоор, 2.0 хувь нь 90-ээс дээш хоногоор, 0.9 хувь нь 30-90 хоногоор зорчжээ. Хилээр гарсан дотоодын зорчигчдын 70.5 хувь нь хувийн, 16.6 хувь нь ажиллах, 6.2 хувь нь жуулчлах, 2.5 хувь нь албан ажлаар, үлдсэн 4.2 хувь нь суралцах, байнга оршин суух, бусад шалтгаанаар гадаадад зорчсон байна.

Гадаадад зорчсон Монгол иргэдийн 74.2 хувь нь БНХАУ-руу, 14.3 хувь нь ОХУ-руу, 4.0 хувь нь БНСУ-руу, 1.2 хувь нь Япон улс руу, үлдсэн 6.4 хувь нь бусад улс орнууд руу зорчжээ.

Зураг 10. Гадаадад зорчсон Монгол иргэд, улс, хувиар, 2019 он



Хилээр гарсан дотоодын зорчигчдыг боомтуудаар нь ангилан харвал, 42.9 хувь нь Замын-Үүд боомтоор, 14.2 хувь нь Гашуун сүхайд, 14.0 хувь нь Буюнт-Ухаа, 11.0 хувь нь Алтанбулаг, 7.0 хувь нь Шивээ хүрэн, 10.9 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

#### ДҮГНЭЛТ

- ✈ Манай улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Улсын хилээр 2009 онд 3.0 сая зорчигч нэвтэрч байсан бол 2019 онд 6.1 сая болж 2 дахин нэмэгдсэн байна.
- ✈ Сүүлийн 10 жилийн хугацаанд гадаадад зорчих Монгол иргэдийн тоо хурдацтай нэмэгдэж байна. Улсын хилээр 2019 онд нэвтэрсэн нийт зорчигчдын 4.8 сая нь дотоодын зорчигчид байсан ба үүнийг 2009 онтой харьцуулахад 2.3 дахин өссөн байна.
- ✈ Хилээр орсон 3.0 сая зорчигчийн 636.7 мянга нь гадаадын иргэд бөгөөд 2009 онтой харьцуулахад 37.0 хувиар, өмнөх оноос 6.4 хувиар өссөн байна.
- ✈ Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 90.5 хувь буюу 577.3 мянга нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн нь 2009 онтой харьцуулахад 40.2 хувиар, өмнөх оноос 9.1 хувиар тус тус өсжээ.
- ✈ Монгол орныг зорих жуулчдын тоо сүүлийн 10 жилд бага өсөлттэй байгаа нь дараах хүчин зүйлээс шалтгаалж байна. Тухайлбал:

- ☹ Манай орны цаг агаарын байдал, ялангуяа жуулчлал хийх дулаан, таатай улирлын хугацаа богино байна. Монгол улсад ирж буй нийт жуулчдын 69.7 хувь нь дулааны улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд ирдэг.
- ☹ Манай улсын болон ялангуяа жуулчны бааз, отогийн дэд бүтцийн хөгжил муу,
- ☹ Монгол улсад ирж, очих агаарын нислэг хязгаарлагдмал, тийзний үнэ өндөр,
- ☹ Төв суурин газрын агаар, хөрсний бохирдол их.
- ☹ Манай оронд өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй, жуулчдыг татах өвлийн арга хэмжээ бага байдаг.

Иймд Монгол орны байгаль, түүх соёл, зан заншлыг сурталчилсан жуулчдыг татах үйл ажиллагааг төлөвлөх, ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх нь чухал байна. Юуны түрүүнд Засгийн газраас хүн ая тухтай амьдрах наад захын нэг нөхцөл буюу дэлхийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж, дэд бүтцийг эрс шинэчлэн сайжруулах хөтөлбөрийг даруй боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм.

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ТОВЧОО